



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 456

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.6, 7.1, 8 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын ерөнхий прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 46,900,000.00 (дөчин зургаан сая есөн зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн автомашиныг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож Цөмийн энергийн комиссын ажлын албанд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Цогтбаатар, Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Г.Манлайжав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

00000000

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн
456 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗРААС ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИСССЫН АЖЛЫН АЛБАНД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ
АВТОМАШИН

Д/д	Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	Цаашид ашиглах (жил)
1	Ниссан Кашкей, 15-97 УБВ, SJNFBNJ10Z2381603, Суудлын автомашин	2011/2011	68117	46,900,000.00	46,900,000.00	5,200,000.00	2
НИЙТ ДҮН							
				46,900,000.00	46,900,000.00	5,200,000.00	2
				(дөчин зургаан сая есөн зуун мянган)	(дөчин зургаан сая есөн зуун мянган)	(таван сая хоёр зуун мянган)	-